

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын протокол**

“Э-Транс Ложистикс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 4 сарын 28-ны өдөр хурлын дэгийн дагуу 14:20 цагт БиДиСек ХК-ийн төв байранд компанийн нийт 40,808,647 ширхэг буюу нийт хувьцааны 88,33% хувийг эзэмшигч 17 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хуралдав. Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар хурлын даргаар хувьцаа эзэмшигч Чулуун овогтой Энхболдыг сонгон хурлын дарга хурлыг нээн, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулан эхлэв.

ХЭХ-д дараах хувьцаа эзэмшигчид оролцов.

№	Нэр	Тоо ширхэг	Хувь
1	Э-Транс ХХК	23,100,000.0	50.00%
2	БиДиСек ХК	12,277,529.0	26.57%
3	ЭМИТиЭф ХХК	290,500.0	0.63%
4	Mongol transportation holdings S.A.R.L	1,917,579.0	4.15%
5	Mongolian transportation holdings S.A.R.L	3,200,000.0	6.93%
6	Ш.Тэргэл	558.0	0.00%
7	Ш.Анужин	638.0	0.00%
8	Д.Төмөрбаатар	12,217.0	0.03%
9	Г.Гансүх	3,400.0	0.01%
10	Д.Янжмаа	1,081.0	0.00%
11	М.Довууч	10.0	0.00%
12	М.Шигшээ	276.0	0.00%
13	З.Энх-Амгалан	250.0	0.00%
14	Стандарт инвестмент	490.0	0.00%
15	Б.Цэрэнжав	10.0	0.00%
16	Д.Энхтуяа	2,500.0	0.01%
17	Н.Дуламжав	1,609.0	0.00%
	<b>Нийт</b>	<b>40,808,647.00</b>	<b>88.33%</b>

Хурлаар хэлэлцэх асуудал:

- a) Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- b) Компанийн 2014 оны бизнес үйл ажиллагааны тайлан
- c) Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг батлах
- d) Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
- e) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- f) ТУЗ-ийн 2015 оны цалин урамшууллын төсөв батлах
- g) Ногдол ашиг тараах эсэх
- h) Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

14:30 цагт хурлаар хэлэлцэх дарааллын дагуу үйл ажиллагааны тайланг компанийн гүйцэтгэх удирдлага болох Ч.Амарсанаа танилцуулан, Компанийн санхүүгийн тайлан,

түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг компанийн Ерөнхий нягтлан бодогч Э.Ариунтуяа танилцуулан, ТУЗ-ийн дарга Ч.Энхболд компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг танилцуулсан бөгөөд хувьцаа эзэмшигчдийн саналын дагуу асуудлыг танилцуулаад шууд асуулт хариулт, санал хэлэх байдлаар явуулахаар болов.

Хувьцаа эзэмшигч М.Довууч:

- Үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Салхин сэнсний тээвэр их сонирхол татлаа ахиж тээвэрлэлт хийх үү.

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

Мэдээж бидний хувьд ч их том ажил болсон. Монголд анх удаа энэ салхин сэнсний тээвэрлэлтийг өөрийн салбар замаар тээвэрлэсэндээ баяртай байна. Цаашид ОХУ-ын эдийн засгийн байдал сайжирвал Ларгус компанитай ярьж тохирсон асуудал байгаа. Тэгвэл энэ 5-н сараас явахаар төлөвлөөд байна.

Хувьцаа эзэмшигч М.Довууч:

- Одоогоор хэдэн ажилтай байна вэ? Дундаж цалингтйн хэмжээ?

Ерөнхий нягтлан бодогч Э.Ариунтуяа:

- Нийт 31 ажилтантай. Дундаж цалин 450,0-500,0 мянган төгрөгийн хооронд байгаа.

Хувьцаа эзэмшигч М.Довууч:

- Ам.долларын зээл авсан юм уу? Хэзээ, ямар зориулалтаар авсан бэ?

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- ХХК байхдаа 450,0 мян ам.долларын зээл авсан. Одоогоор зээлээ төлөөд 130,0 орчим мянган ам.долларын зээл үлдээд байна.

Хувьцаа эзэмшигч Ц.Чимгээ:

- Уг зээлийн төлж дуусах хугацаа хэзээ вэ?

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- Эдийн засгийн хямралын зэрэг тодорхой нөхцлөөс хамаараад 2015 онд үндсэн зээлээс чөлөөлүүлж, зөвхөн хүү төлөх гэрээг байгуулсан. Аль болох хурдан хугаанд төлж барагдуулахын төлөө ажиллаж байна. Уг зээлийг авч байх үед ам.долларын төгрөгтэй харьцах ханш 1380 төгрөг байсан бөгөөд тухайн үед хамгийн боломжит зээл байсан хэдий ч долларн ханш их өсөлттэй байна. Зээлийн хугацаа 2017 онд дуусахаар байгаа хэдий ч хугацаанаас өмнө төлж барагдуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч Н.Дуламжав:

- Санхүүгийн үзүүлэлтээр удирдлагын зардал 2 дахин буурсан байна. Энийг тодруулвал?

Ерөнхий нягтлан бодогч Э.Ариунтуяа:

- Манайх өмнө жилүүдэд зөвхөн төмөр замын тээврийн хөлсийг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт оруулан тооцдог байсан бол энэ жил аудитын шалгалтаар үндсэн үйл ажиллагааны зардлыг борлуулалт болон удирдлагын зардлаар нь салган тооцоолсноор удирлагын зардлын дүн буурсан байдалтай санхүүгийн тайланд харагдаж байгаа. Компанийн зардалд элэгдлийн зардал их хувь эзэлж байгаа. Нэг цэгийн үйлчилгээний барилга болоод бусад шинээр барьж байгуулсан үл хөдлөх хөрөнгийн элэгдлийн зардал болоод үл хөдлөх хөрөнгийн албан татвар 0,6%-1% болж өссөн.
- Хувьцаа эзэмшигч Н.Дуламжав:
- Танайх амралтын өдөр ажилладаг уу?

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- Манай компани нь 24-н цагийн тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг. Зуны ачаалалтай саруудад амралтын өдөр гэж байхгүй. Байнгын үйл ажиллагаа явуулдаг учраас бид гааль болон мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг хэвийн явуулах үүднээс хариуцлагатай байдаг. Манайхаар үйлчлүүлдэг үйлчлүүлэгч нар ер нь нэг дороос бүх үйлчилгээг авч чаддаг.

Хувьцаа эзэмшигч Н.Дуламжав:

- Танай компанийн бизнесийн онцлог алдагдалтай ажиллах нөхцөлгүй компани. Гэтэл хувьцааны ханш яагаад өсөхгүй байна вэ?

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- Манай компани өвлийн улиралд алдагдалтай ажилладаг. Компанийн орлогын хэмжээ ачаа эргэлтээс, ачаа шилжүүлэн тээвэрлэлтийн хэмжээнээс хамаардаг. Ачаа явж л байвал манайх ашигтай ажиллана. Гэвч статистик үзүүлэлтээр ачаа эргэлтийн хэмжээ буурч байна. Төмөр зам үнийн тарифаа нэмсэн. Харин манайх үйлчлүүлэгч нарыг алдахгүйн тулд бид тарифаа нэмээгүй. Иймд манай ачилтын статистик үзүүлэлт төмөр замаас илүү сайн үзүүлэлттэй байгаа. Мэдээж цаашид үйл ажиллагааныхаа хүрээг өргөтгөхөөр олон ажил санаачлан ажиллаж байна. Шинэ ажил хийхэд бас хөрөнгө мөнгөний асуудал их гардаг ч илүү ихийг бүтээн байгуулахаар зорилт тавин ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч М.Шигшээ:

- Компаниуд төмөр замтай гэрээтэй байдаг, шууд МЧ II дээр буулгадаг биз дээ.

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- Тэр хүмүүсийн сонголт л доо. Заавал гэрээтэй байдаггүй ачаагаа хаана буулгах нь тэдний сонголт, хаана ч ирж үйлчлүүлж болно. Манайх байршлын хувьд илүү давуу талтай. Нэг цэгийн үйлчилгээ байдаг тул түргэн шуурхай байдаг. Харин дутагдалтай талын хувьд МЧ-г бодвол манайх төмөр замын фронт бага. Манайх 33 воганы фронттой бол МЧ III 160 воганы фронттой.

Компанийн гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа 2015 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа:

- Үйл ажиллагааны төлөвлөгөөн дээр шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх гэж байна. Энд юу орж байна вэ?

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- Гаалийн зуучлалын үйл ажиллагааг нэвтрүүлэх, урамшуулал болон борлуулалтын хөнгөлөлт эдлүүлэх тал дээр 1 илгээгч сард 100-н вагоноос дээш ачаа ачсан бол тээврийн хөлснөөс хөнгөлөлт үзүүлэх талаар судлан, тооцоо судалгааг хийж байна. Стандартын бус ачааг ачих, транзит ачаа, контейнар зэргийг ачих зэрэг судалгааг хийж байна. Өмнө нь тээвэрч дэлбэрэх ачааг ачдаггүй байсан. Бид уг зөвшөөрлийг авч чадсан. Тээврийг дан ганц төмөр замаар биш авто замаар хүргэх гэх мэтчилэн бодож төлөвлөсөн ажил их байна.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа:

- Үйл ажиллагааны хувьд төлөвшсөн, компанийг сайн авч яваа харагдаж байна. Үнэхээр сэтгэгдэл өндөр байна. Үнэхээр хүнд салбар би ч бас өөрөө энэ салбарт ажиллаж байсан. Илүү ихийг бүтээн байгуулж сайн ажиллахын хүсэн өрөөө удирдлага болон та бүгдэд амжилт хүсье.

ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчид болон ТУЗ-ийн 2015 оны цалин урамшууллын төсвийг ТУЗ-ийн дарга Ч.Энхболд хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа:

- ТУЗ-ийн гишүүд цалингүй ажилладаг юм уу.

ТУЗ-ийн дарга Ч.Энхболд:

- ТУЗ-ийн гишүүд цалингүй ажилладаг.

Хувьцаа эзэмшигч Д.Энхтуяа:

- Байнгын болон улирлын ажилчдын тоо хэд байна вэ?

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- Байнгын ажилчдын тоо 31 байна. Улирлаас хамаарч түр ажилчдын тоо 150-180 хүн ажилладаг. Гэхдээ улирлаас хамаарч ажилладаг хүмүүс манай компанийн ажилчдад хамаарч явдаггүй.

Хувьцаа эзэмшигч Б.Цэрэнжав:

- Надад компанийн үйл ажиллагаатай холбоотой хэдэн асуулт байна. ХК болоод 3 жил боллоо. ХК болон ХХК 2-ын хоорондын ялгаа юу байна вэ? Хэдэн хувьцаа эзэмшигчтэй байна вэ? Үүнээс хувьцааны төвлөрөл хэд вэ? Төвлөрлийг бууруулах тал дээр ямар арга хэмжээ авах вэ? Замын-Үүдэд чөлөөт бүс байгуулагдах ажил ямар явцтай явагдаж байна вэ?

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- ХК болоод татсан санхүүжилтээрээ оффисын барилга болон тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийсэн. ХК-ийн нэг давуу тал нь компанийн

мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байдаг үүнтэй холбоотой байнгын шалгалт их байдаг тэр нь ч амар байдаг. Харин сул талын хувьд шийдвэр гаргах явц удаашралтай, ТУЗ-өөр батлуулна. ТУЗ-ийн эрх мэдлээс дээгүүр бол ХЭХ-аар батлуулна. ХЭХ хуралдуулахад цаг хугацаа их шаардана гэх мэт.

2015 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн тархалтын судалгаагаар манай компани нь нийт 355 хувьцаа эзэмшигчтэй байна. Үүнээс уг танилцуулга дээр байгаа 5%-аас дээш хувьцаа эзэмшигчид болох 3 хувьцаа эзэмшигч нь нийт хувьцааны 83.5%-ийг эзэмшиж байна.

Чөлөөт бүс байгуулагдах ажил олон жилийн турш яригдаж байна. Би хуралд нь олон удаа сууж байсан. Одоогоор яг тодорхой нарийн төлөвлөж хийсэн зүйл байхгүй байна.

ТУЗ-ийн дарга Ч.Энхболд:

- Хувьцаа төвлөрлийн тал дээр Э-Транс ХХК нь анх Э-Транс Логистикс ХК-ийг Хөрөнгийн зах зээл дээр хувьцаа гаргахад нийт хувьцааны 50%-ийг эзэмшилдээ авч үлдсэн. Үүнээс хойш эзэмшил дэх хувьцааны тоо хэмжээг ихэсгээгүй. Бусад томоохон хувьцаа эзэмшигчдийн хувьд хувьцаагаа зарах асуудал нь өөрсдийнх шийдвэр тул "Э-Транс Логистикс" ХК-иас үүнд оролцох эрх байдаггүй.

Хувьцаа эзэмшигч М.Шигшээ:

- Нүүрс шилжүүлэн ачих тал дээр яаж ажиллаж байна вэ?

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- Өмнө нь манайх өдөрт 10-20 вагон нүүрс шилжүүлэн ачдаг байсан. Гэвч манай нүүрс шилжүүлэн ачих зөвшөөрлийг хүчингүй болгосон. Бид анх нүүрс ачих зөвшөөрлийг авч туузан конвейрыг ажиллуулан вагоноос машинд нүүрсийг шилжүүлэн ачиж механикжуулан амжилттай явуулж байсан. Үйл ажиллагаа хэвийн явагдаж байтал төмөр замаас манай дээр нүүрс шилжүүлэн ачихыг хаасан.

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа ТУЗ-ийн ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Хувьцаа эзэмшигч М.Шигшээ:

- Дараагийн жил ногдол ашиг тараах төлөвлөгөө байна уу?

ТУЗ-ийн гишүүн С.Отгонбаяр:

- Ногдол ашиг тараахаар төлөвлөж хичээж байгаа хэдий ч компани нь эхлээд өр зээлээ төлөөд дараа нь ногдол ашиг тараахгүй бол зээлийн хүүгийн төлбөр нь компанид зардлыг бий болгож байна.

Хувьцаа эзэмшигч Д.Төмөрбаатар:

- Экспортоос хамаарч хувирах чадвар хэр байна вэ?

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- Хувирах чадвартай.

Хувьцаа эзэмшигч Д.Төмөрбаатар:

- Компани дээр очиж үзэх боломжтой юу?

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- Тэгэлгүй яахав. Компанийн үйл ажиллагаатай биечлэн очиж ил тод танилцаж болно. Бид дуртайяа хүлээн авч компаниа танилцуулах болно.

Компанийн дүрмийн өөрчлөлтийг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа хуралд оролцогчдод танилцуулсан бөгөөд хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийн дүрмийн өөрчлөлттэй холбогдох асуулт байхгүй байв.

Хувьцаа эзэмшигч Г.Гансүх:

- Компани нь ХК болсноос хойш чамлалтгүй амжилттай ажиллаж байгаа гэж дүгнэж байна. Гол нь туршлагатай хүмүүс ингэж ажиллаж байгаад баяртай байна.

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- Баярлалаа эдийн засгийн хямрал зэргээс болоод бид үйл ажиллагаандаа томоохон амжилт гаргаж чадаагүй ч гэсэн. Компанийн үйл ажиллагаанд доголдол гаргалгүй ажиллаж байна. Бид энэ хямралыг хямрал гэж харалгүй бас боломж гэж харж байна.

Хувьцаа эзэмшигч Д.Төмөрбаатар:

- Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах талаар яарах хэрэггүй байх. Компаниа илүү өргөжүүлэх тал дээр анхаарч хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигч Б.Цэрэнжав:

- Би Замын-Үүдэд "Э-Транс Ложистикс" ХК-ийн оффис дээр очиж үзсэн их том байгууламж байна лээ. Сайхан байсан тэгээд хувьцааг нь худалдан авахаар шийдсэн.

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

- Ер нь бол Замын-Үүдэд манайх томоохон татвар төлөгчид ордог. Үйл ажиллагааны хувьд ч тогтворжсон.

Хувьцаа эзэмшигчдийн асуулт хариулт, санал оруулах үйл ажиллагаа дуусч, 16:30 цагт санал хураах ажиллагаа явагдав. Санал хураалтанд нийт 40,808,647 ширхэг буюу нийт хувьцааны 88,33% хувийг эзэмшигч 17 хувьцаа эзэмшигч өөрсдийн саналыг саналын хуудас бөглөн өгсөн бөгөөд үүнээс 1 саналын хуудас хүчингүй, 16 саналын хуудас хүчинтэй байлаа. 16:40 цагт тооллогын комиссын тогтоолыг танилцуулав. Санал хураалтаар:

1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.
2. Компанийн бизнес үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.

3. Компанийн 2015 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлан 2014 оны ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллахыг төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгов.
4. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.
5. Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг 100% зөвшөөрөн Ч.Энхболд, Ч.Амарсанаа, С.Отгонбаяр, С.Санжаа, Б.Пүрэвбаатар, Б.Батбаатар, Х.Батхишиг, А.Батболд, Б.Лхагвадорж нарыг сонгов.
6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014 оны зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар 14,840,000 төгрөгөөр батлав.
7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн хувьцаа эзэмшигчдийн 99,9994%-ийн саналаар батлав.
8. “Э-Транс Ложистикс” ХК нь ихээхэн өртэй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй болох ТУЗ-ийн тогтоолыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулсан.

16:50 цагт Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолын шийдвэрийг танилцуулан дуусч, хурлын дарга Ч.Энхболд хурлыг албан ёсоор хаав.

Хурлын дарга:



Ч.Энхболд

Хурлын протокол хөтөлсөн:



Г.Гэрэлт-Од